



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/122/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АРХАНГАЙ ЦАХИР ИТХ-ЫН ДАРГА
Т.ТЭРБИШ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цахир сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цахир сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	128,300.00	127,800.00
2	БАРАА МАТЕРИАЛ	128,300.00	127,800.00
3	Хангамжийн материал	128,300.00	127,800.00
4	Бичиг хэргийн материал	56,800.00	56,300.00
5	Аж ахуйн материал	71,500.00	71,500.00
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,100,666.92	12,112,570.19
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,100,666.92	12,112,570.19
8	Газар	0.00	0.00
9	Биет хөрөнгө	2,100,666.92	12,112,570.19
10	Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,714,000.00	13,855,000.00
11	Хуримтлагдсан элэгдэл	-10,041,999.92	-1,921,033.27
12	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,257,460.00	638,840.00
13	Хуримтлагдсан элэгдэл	-828,793.16	-460,236.54
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,228,966.92	12,240,370.19
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,228,966.92	12,240,370.19
16	Засгийн газрын хувь оролцоо	2,228,966.92	12,240,370.19
17	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	679,000.00	679,000.00
18	Хуримтлагдсан үр дүн	1,525,089.62	11,536,492.89
19	Өмнөх үеийн үр дүн	3,876,789.38	1,525,089.62
20	Тайлант үеийн үр дүн	-2,351,699.76	10,011,403.27
21	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
22	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,877.30	24,877.30
23	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,228,966.92	12,240,370.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,270,200.00	70,124,340.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	8,922,840.00
3	Нийтлэг татварын бус орлого	0.00	8,922,840.00
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	8,922,840.00
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,270,200.00	61,201,500.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,260,000.00
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,260,000.00
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,270,200.00	59,941,500.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,270,200.00	59,941,500.00
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	58,621,899.76	59,949,603.29
11	УРСГАЛ ЗАРДАЛ	58,621,899.76	59,949,603.29
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,271,909.78	56,633,765.52
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,205,010.66	41,052,200.00
14	Үндсэн цалин	40,205,010.66	40,212,200.00
15	Урамшуулал	0.00	840,000.00
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,891,429.36	4,982,432.23
17	Тэтгэврийн даатгал	3,336,261.75	3,467,832.71
18	Тэтгэмжийн даатгал	388,793.16	378,649.88
19	ҮОМШӨ-ний даатгал	311,037.71	302,919.84
20	Ажилгүйдлийн даатгал	77,757.44	75,730.04
21	Эрүүл мэндийн даатгал	777,579.30	757,299.76
22	Хангамж, бараа материалын зардал	5,035,770.00	4,845,190.00
23	Бичиг хэрэг	2,694,100.00	2,311,290.00
24	Тээвэр, шатахуун	2,141,670.00	2,449,900.00
25	Ном, хэвлэл	200,000.00	84,000.00
26	Нормативт зардал	0.00	2,000,000.00
27	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2,000,000.00
28	Томилолт, зочны зардал	276,000.00	150,000.00
29	Гадаад албан томилолт	0.00	0.00
30	Дотоод албан томилолт	276,000.00	150,000.00
31	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,400.00	1,325,340.00
33	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,400.00	1,190,340.00
34	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	135,000.00
35	Бараа үйлчилгээний бусад зардал	3,641,299.76	2,278,603.29
36	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	500,000.00
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,489,300.00	420,000.00
38	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,151,999.76	1,358,603.29
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,349,989.98	3,315,837.77
40	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,349,989.98	3,315,837.77
41	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,349,989.98	3,315,837.77
42	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,351,699.76	10,174,736.71
43	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	163,333.44
44	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	163,333.44
45	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,351,699.76	10,011,403.27

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	3,876,789.38	4,580,666.68
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,000.00	24,877.30	3,876,789.38	4,580,666.68
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,351,699.76	-2,351,699.76
3	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	1,525,089.62	2,228,966.92
4	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	1,525,089.62	2,228,966.92
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,000.00	24,877.30	1,525,089.62	2,228,966.92
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,011,403.27	10,011,403.27
7	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	679,000.00	24,877.30	11,536,492.89	12,240,370.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	56,270,200.00	61,201,500.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,270,200.00	61,201,500.00
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,260,000.00
4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,260,000.00
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,270,200.00	59,941,500.00
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,270,200.00	59,941,500.00
7	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,270,200.00	58,590,500.00
8	УРСГАЛ ЗАРДАЛ	56,270,200.00	58,590,500.00
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,920,210.02	55,274,662.23
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,205,010.66	41,052,200.00
11	Үндсэн цалин	40,205,010.66	40,212,200.00
12	Урамшуулал	0.00	840,000.00
13	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,891,429.36	4,982,432.23
14	Тэтгэврийн даатгал	3,336,261.75	3,467,832.71
15	Тэтгэмжийн даатгал	388,793.16	378,649.88
16	ҮОМШӨ-ний даатгал	311,037.71	302,919.84
17	Ажилгүйдлийн даатгал	77,757.44	75,730.04
18	Эрүүл мэндийн даатгал	777,579.30	757,299.76
19	Хангамж, бараа материалын зардал	4,836,070.00	4,844,690.00
20	Бичиг хэрэг	2,494,400.00	2,310,790.00
21	Тээвэр, шатахуун	2,141,670.00	2,449,900.00
22	Ном, хэвлэл	200,000.00	84,000.00
23	Нормативт зардал	0.00	2,000,000.00
24	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	2,000,000.00
25	Томилолт, зочны зардал	276,000.00	150,000.00
26	Гадаад албан томилолт	0.00	0.00
27	Дотоод албан томилолт	276,000.00	150,000.00
28	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,400.00	1,325,340.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,400.00	1,190,340.00
31	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	135,000.00
32	Бараа үйлчилгээний бусад зардал	1,489,300.00	920,000.00
33	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	500,000.00
34	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,489,300.00	420,000.00
35	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,349,989.98	3,315,837.77
36	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,349,989.98	3,315,837.77
37	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,349,989.98	3,315,837.77
38	Хөрөнгийн	0.00	0.00
39	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	2,611,000.00
40	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,611,000.00
41	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,611,000.00
42	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,611,000.00
43	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2,611,000.00
44	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,611,000.00
VIII	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,941,500.00	56,625,662.23	3,315,837.77	94.5%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	59,941,500.00	56,625,662.23	3,315,837.77	94.5%
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,941,500.00	56,625,662.23	3,315,837.77	94.5%
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,212,200.00	40,212,200.00	0.00	100.0%
5	Үндсэн цалин	40,212,200.00	40,212,200.00	0.00	100.0%
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,428,600.00	4,982,432.23	446,167.77	91.8%
7	Тэтгэврийн даатгал	3,820,200.00	3,467,832.71	352,367.29	90.8%
8	Тэтгэмжийн даатгал	402,100.00	378,649.88	23,450.12	94.1%
9	ҮОМШӨ-ний даатгал	321,700.00	302,919.84	18,780.16	94.1%
10	Ажилгүйдлийн даатгал	80,400.00	75,730.04	4,669.96	94.1%
11	Эрүүл мэндийн даатгал	804,200.00	757,299.76	46,900.24	78.6%
12	Хангамж, бараа материалын зардал	6,165,700.00	4,844,690.00	1,321,010.00	97.0%
13	Бичиг хэрэг	2,381,700.00	2,310,790.00	70,910.00	66.2%
14	Тээвэр, шатахуун	3,700,000.00	2,449,900.00	1,250,100.00	100.0%
15	Ном, хэвлэл	84,000.00	84,000.00	0.00	100.0%
16	Нормативт зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
17	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
18	Эд хогшил, урсгал засварын зардал	2,050,000.00	2,050,000.00	0.00	99.9%
19	Багаж, техник, хэрэгсэл	2,050,000.00	2,050,000.00	0.00	100.0%
20	Томилолт, зочны зардал	150,000.00	150,000.00	0.00	100.0%
22	Дотоод албан томилолт	150,000.00	150,000.00	0.00	100.0%
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,935,000.00	1,886,340.00	48,660.00	97.5%
25	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00	1,751,340.00	48,660.00	97.3%
26	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	135,000.00	135,000.00	0.00	100.0%
27	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	500,000.00	1,500,000.00	25.0%
28	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	500,000.00	1,500,000.00	25.0%
29	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,941,500.00	56,625,662.23	3,315,837.77	94.5%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,391,500.00	56,625,662.23	4,234,162.23	94.5%
33	Орон нутгийн төсвөөс	52,391,500.00	56,625,662.23	4,234,162.23	94.5%
34	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,550,000.00	0	7,550,000.00	87.9%
35	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,550,000.00	0	7,550,000.00	87.9%
36	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	5	5	0	5
37	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	1
38	Төсвийн байгууллага	1	1	0	1
39	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0	0
40	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	0	2
41	Удирдах ажилтан	1	1	0	1
42	Гүйцэтгэх ажилтан	1	1	0	1
43	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2	2	0	2
44	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	0	1
45	Гэрээт ажилтан	0	0	0	0
46	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	0	1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд бараа материалын тайланг нэр төрөл тус бүрээр бэлтгэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахир сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цахир сумын ИТХ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага бөгөөд иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй удирдлагаар хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд "ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг ханган, иргэдийн оролцоог дэмжин ажиллана" гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахир сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 67.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 2.2 сая төгрөгөөр буюу 55.5 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	0.1	0.1	0.0	(0.4)
Үндсэн хөрөнгө	13.0	14.5	1.5	11.7
Нийт хөрөнгө	2.2	12.2	10.0	55.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2.2	12.2	10.0	55.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2.2	12.2	10.0	55.5

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 55.5 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 13.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.6 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 9.0 сая, нийт 11.6 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн бол 11.1 сая төгрөгийн хөрөнгийг актлаж, тайлант

хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 1.4 сая төгрөг нийт 12.5 сая төгрөгөөр буурч 12.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг 10.0 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56.3	59.9	3.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1.3	1.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	8.9	8.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	-	-
Үйл ажиллагааны орлого	56.3	70.1	13.9
Цалин, шимтгэлийн зардал	45.1	46.0	0.9
Бусад бараа үйлчилгээний зардал	5.3	7.0	1.7
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.2	1.3	1.1
Бараа үйлчилгээний бусад зардал	3.6	2.3	(1.4)
Үйл ажиллагааны зардал	54.27	56.6	2.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2.00	13.49	11.5

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр 0.9 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтээс 3.3 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 66.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 6.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 59.9 сая төгрөгөөр хянаж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 59.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 59.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 56.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 3.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь ажил олгогчоос төлөх НДШ 0,4 сая төгрөг, тээвэр шатахуун 1.3 сая төгрөг, бичиг хэрэг 0.07 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 1.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хурааж зардлаас 0.05 сая төгрөг нийт 3.3 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 0.8 сая төгрөгийг хүлээн авч, нэн удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төсөвтөө төлөвлөн тус чиглэлийн хүрээнд сумын цагдаагийн тасагтай хамтран ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 2 үндсэн зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ИТХ-ын даргаас 90 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 59.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 56.6 сая төгрөгийг зарцуулж, 94.4 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд албан томилолт болон бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан ба судалгааны бусад асуудлууд хамааралгүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тариат сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 146 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгалаа. Хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Нормын хувцас зөөлөн эдллийн зардлаас 2.0 сая төгрөгийн өвөл зуны ажлын хувцас, дүрэмт хувцас бэлтгэж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЗГ-ын 2021 оны 43 тогтоолыг мөрдөж үр ашиггүй хөрөнгө зарцуулахгүй байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээллээгүй зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсний хэрэгжилтийг үнэлэхэд 85 хувь байна.

3.11. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Иймд Зөрчилгүй дүгнэлт өглөө.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цахир сумын ИТХ	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цахир сумын ИТХ	1	2.0	0	0	1		1	2.0	1	0
	Дүн	1	2.0	0	0	1		1	2.0	1	0
	Нийт дүн	2	2.0	0	0	1		1	2.0	1	0

